



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/23/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа.....	14
3.5.4 Бараа материал.....	14
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	14
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.7 Өр төлбөр.....	15
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/242
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчид нь зөвхөн гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

Тайлант онд Аймгийн болон сумын хөрөнгө оруулалтаар Төрийн албан хаагчдын 4 айлын орон сууцны барилгын ажлыг Хоби Ану ХХК 200,000.0 мянган төгрөгөөр 90 хувийн гүйцэтгэлтэй, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 70,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ЭМТ-ийг усан хангамжтай холбож угаалга, бие засах өрөө байгуулах бохир усны шингэн соруулах цооногийн ажил, хүүхдийн тоглоомын талбайг 12,900.0 мянган төгрөгөөр Нар Хүслийн хотхон ХХК-аас 8 нэр төрлийн тоглоомыг хүлээн авсан, Сургуулийн биеийн тамирын гадна талбайг 13,000.0 мянган төгрөгөөр Шинэ эрин инженеринг ХХК хийж гүйцэтгэсэн зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Нийгмийн хариуцлагын гэрээнд заасан сум орон нутгаас зохион байгуулж байгаа олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох гэсэн заалтын дагуу МЧМеталл ХХК, Баянжонш ХХК, Баянцемент ХХК, Иргэн Ө.Ууганжаргал, Иргэн С.Чулуун нараас нийт 10,500.0 мянган төгрөгийн хандив авч Төв түмний цэнгэл наадамд зарцуулсан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 83,27 буюу "Б" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 262,298.3 мянган төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр нийт 400,221.4 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 137,923.4 мянган төгрөгөөр буюу 152,6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичгээр өгсөн заавар чиглэлийн дагуу орон нутгийн улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 4,039,709.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 203,547.3 мянган төгрөгийн бараа материал, 31,416.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 50,535.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhib/Alban bichig 2023/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨ РӨ НГИЙН ДҮН		1,489,794.4	1,433,480.8
31	МӨ НГӨ Н ХӨ РӨ НГӨ	3а, 3б	814,129.4	905,058.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	311,596.3	377,554.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	364,068.6	150,867.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨ РӨ НГИЙН ДҮН		5,219,572.2	1,480,068.0
39	ҮНДСЭН ХӨ РӨ НГӨ	12а, 12б, 12в	5,219,572.2	1,480,068.0
39200	Биет хөрөнгө		5,162,364.2	1,476,852.0
39300	Биет бус хөрөнгө	13	57,208.0	3,216.0
3	НИЙТ ХӨ РӨ НГИЙН ДҮН III=I+II		6,709,366.6	2,913,548.8
4	НИЙТ Ө Р ТӨ ЛБӨ Р		4,257.7	11,358.8
41	БОГИНО ХУГАЦААТ Ө Р ТӨ ЛБӨ Р	15а, 15б	4,257.7	11,358.8
41300	Ө глөг	17а, 17б	4,257.7	11,358.8
5	ЦЭВЭР ХӨ РӨ НГӨ Ө МЧИЙН ДҮН		6,705,108.9	2,902,190.0
51	Засгийн газрын хувь оролцоо		6,705,108.9	2,902,190.0
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,266,753.6	481,759.6
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,266,753.6	481,759.6
51200	Хуримтлагдсан үр дүн		3,456,434.2	2,117,902.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,981,921.1	302,527.6
6	Ө Р ТӨ ЛБӨ Р, ЦЭВЭР ХӨ РӨ НГӨ Ө МЧИЙН ДҮН VI=IV+V		6,709,366.6	2,913,548.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,568,547.3	1,631,158.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		60,306.6	229,910.6
110	Орлогын албан татвар		46,442.8	184,285.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		46,442.8	189,976.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-5,691.3
113	Хөрөнгийн албан татвар		660.0	27,867.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		13,203.8	17,757.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	309,730.8	488,200.0
120	Нийтлэг татварын бус орлого		309,730.8	488,200.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,198,509.9	913,047.5

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,757,937.3	1,106,066.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,757,937.3	903,446.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,870,701.8	874,754.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,056,404.1	292,992.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		138,161.7	34,682.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		237,786.7	248,615.2
2104	Хангамж, бараа материалын зардал		148,095.3	64,894.3
2105	Нормативт зардал		48,963.3	29,488.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,630.0	12,080.3
2107	Томилолт, зочны зардал		6,718.0	6,208.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,013.5	29,873.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		222,929.2	155,920.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		887,235.5	28,692.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	202,619.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		810,610.0	525,092.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		130,747.3	4,247,873.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		679,862.7	-3,722,781.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,384,004.4	1,400,759.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	60,916.4	229,910.6
110	Орлогын албан татвар	47,052.6	184,285.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,052.6	189,976.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-5,691.3
113	Хөрөнгийн албан татвар	660.0	27,867.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	13,203.8	17,757.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,015.6	2,622.6
1181	Газрын төлбөр	8,048.1	13,135.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	140.0	2,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,640.8	259,759.6
120	Нийтлэг татварын бус орлого	134,640.8	259,759.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,188,447.2	911,088.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,652,579.2	828,509.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,652,579.2	828,509.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,757,361.0	769,853.4

2101	Цалин хө лс болон нэмэгдэл урамшил	1,054,975.5	292,992.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд тө лө х шимтгэл	138,161.7	34,682.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,985.8	248,615.2
2104	Хангамж, бараа материалын зардал	59,525.7	28,828.4
2105	Нормативт зардал	66,682.1	29,627.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,185.7	13,869.4
2107	Томилолт, зочны зардал	6,868.0	4,674.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө лбө р, хураамж	6,718.2	32,936.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,258.2	83,627.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮ ЛЭГ	895,218.2	58,655.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	731,425.2	572,249.9
V	ХӨ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН МӨ НГӨ Н ЗАРДЛЫН ДҮН (V)	226,350.6	381,955.0
22	ХӨ РӨ НГИЙН ЗАРДАЛ	226,350.6	381,955.0
2200	Дотоод эх үүсвэрээр	226,350.6	381,955.0
VI	ХӨ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-226,350.6	-381,955.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-200.0	-99,365.4
23	ЭРГЭЖ ТӨ ЛӨ ГДӨ Х ТӨ ЛБӨ РИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200.0	99,365.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	504,874.6	90,929.4
101	Мө нгө , түүнтэй адилтгах хө рө нгийн эхний үлдэгдэл	309,254.8	814,129.4
20	Мө нгө , түүнтэй адилтгах хө рө нгийн эцсийн үлдэгдэл	814,129.4	905,058.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хө рө нгө /ө мч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,025,223.50	6,025,223.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын ө ө рчлө лт	22.8	22.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,025,246.30	6,025,246.30
9	Тайлант үеийн үр дүн	679,862.70	679,862.70
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,705,108.90	6,705,108.90
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,705,108.90	6,705,108.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын ө ө рчлө лт	-80,137.20	-80,137.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,624,971.70	6,624,971.70
19	Тайлант үеийн үр дүн	-3,722,781.70	-3,722,781.70
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,902,190.00	2,902,190.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,751,502.7	1,081,885.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,231.1	700,565.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	733,731.1	697,158.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,287.9	292,992.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,885.8	34,682.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	259,402.0	248,615.2
2104	Хангамж, бараа материалын зардал	25,929.1	25,851.8
2105	Нормативт зардал	500.0	500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,030.0	13,869.4
2107	Томилолт, зочны зардал	4,698.4	4,674.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,538.9	32,636.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,459.0	43,336.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500.0	3,407.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500.0	3,407.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	841,271.6	281,955.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	173,000.0	99,365.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,751,502.7	1,049,814.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	240,214.6	240,214.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	774,231.1	753,860.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	737,057.0	55,738.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	734,852.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	673,862.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Ө мнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,036,614.7	190,787,138.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,036,614.7	90,787,138.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,898,251.6	43,432,510.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,040,974.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,370,960.0	2,976,640.0
2105	Нормативт зардал	10,159,900.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,085.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,442,262.6	300,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,884,070.0	40,155,870.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,138,363.1	47,354,627.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,770,600.0	23,832,200.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,367,763.1	23,522,427.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	100,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	100,000,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,534,550.7	188,289,202.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	237,534,550.7	188,289,202.1
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,497,936.0	-2,497,936.0

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	2,497,936.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,497,936.0	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Төв аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант онд Аймгийн болон сумын хөрөнгө оруулалтаар Төрийн албан хаагчдын 4 айлын орон сууцны барилгын ажлыг Хоби Ану ХХК 200,000.0 мянган төгрөгөөр 90 хувийн

гүйцэтгэлтэй, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 70,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ЭМТ-ийг усан хангамжтай холбож угаалга, бие засах өрөө байгуулах бохир усны шингэн соруулах цооногийн ажил, хүүхдийн тоглоомын талбайг 12,900.0 мянган төгрөгөөр Нар Хүслийн хотхон ХХК-аас 8 нэр төрлийн тоглоомыг хүлээн авсан, Сургуулийн биеийн тамирын гадна талбайг 13,000.0 мянган төгрөгөөр Шинэ эрин инженеринг ХХК хийж гүйцэтгэсэн зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Нийгмийн хариуцлагын гэрээнд заасан сум орон нутгаас зохион байгуулж байгаа олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох гэсэн заалтын дагуу МЧМеталл ХХК, Баянжонш ХХК, Баянцемент ХХК, Иргэн Ө.Ууганжаргал, Иргэн С.Чулуун нараас нийт 10,500.0 мянган төгрөгийн хандив авч Төв түмний цэнгэл наадамд зарцуулсан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 83,27 буюу “Б” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт огт хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сум нь Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,795,817.8 мянган төгрөгөөр буюу 51,03 хувиар буурсан байна. Энэ нь Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10/84 тоот албан бичигт орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан руу шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	814,129.4	905,058.9	90,929.5
Авлага	311,596.3	377,554.6	65,958.3
Бараа материал	364,068.6	150,867.3	-213,201.3
Үндсэн хөрөнгө	5,219,572.2	1,480,068.0	-3,739,504.2
Нийт хөрөнгө	6,709,366.5	2,913,548.8	-3,795,817.7
Өр төлбөр	4,257.7	11,358.8	7,101.1
Засгийн газрын хувь оролцоо	6,705,108.9	2,902,190.0	-3,802,918.9
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	6,709,366.6	2,913,548.8	-3,795,817.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 905,058.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,929.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлого 149,970.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 12,045.0 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 377,554.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,958.3 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 50,535.5 мянган төгрөгийн авлагыг шилжүүлэн хасагдсан ч Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 63,064.5 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сан 55,700.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,867.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 213,201.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 203,547.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,480,068.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,739,504.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,039,709.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 11,358.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,101.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сан 8,799.0 мянган төгрөгөөр, БНСБС 500.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,902,190.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,802,918.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 3,802,918.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 905,058.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,929.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Кассанд байгаа бэлэн мөнгө	0	211.1	211.1
Төгрөг	0	211.1	211.1
Банкинд байгаа бэлэн мөнгө	814,129.4	904,847.7	90,718.3
Төгрөг	814,129.4	904,847.7	90,718.3
Төрийн сангийн харилцах	813,141.7	900,456.8	87,315.1
Арилжааны банк дахь харилцах	987.7	4,390.9	3,403.2
Дүн	814,129.4	905,058.8	90,929.4

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 900,456.8 мянган төгрөгийн 68,8 хувь буюу 619,174.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сан, 24,3 хувь буюу 218,454.0 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого, 6,0 хувь буюу 54,688.2 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сан, 0,9 хувь буюу 8,140.0 мянган төгрөгийг БНСБС-ийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 4390,9 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 905,058.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,929.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлого 149,970.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 12,045.0 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

ОНХС-аас Баг 97 төслийн хүрээнд багийн дарга нарыг унаажуулах гэсэн арга хэмжээ батлагдаж 5 багийн Засаг даргын мотоциклийн үнийн 50 хувь 7,500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан ОНХС-ийн журмын 4.5-д заасныг зөрчсөн тул албан шаардлага өгсөн.

ЭЭС-аас Төв эм хангамж ХХК-аас эм, эмнэлгийн хэрэгсэл авахаар шилжүүлсэн мөнгийг орлого авсан эсэхийг тулган шалгахад 11,442.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл орлого аваагүй зөрүүтэй байсан тул зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 377,554.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,958.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+)
			Бууралт(-)
Бусад авлага	311,596.3	377,554.7	65,958.4
Байгууллагаас авах авлага	136,903.2	146,336.3	9,433.1
Хувь хүмүүсээс авах авлага	174,693.2	231,218.4	56,525.2
Дүн	311,596.3	377,554.7	65,958.4

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 377,554.7 мянган төгрөгийн 61,2 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 38,7 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 98,8 хувь буюу 228,493.8 мянган төгрөг хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 99,4 хувь буюу 145,413.5 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 377,554.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,958.3 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 50,535.5 мянган төгрөгийн авлагыг шилжүүлэн хасагдсан ч, Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 63,064.5

мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сан 55,700.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт Тус сумын ЭЭС нь Төв эм хангамж ХХК-аас 26,900.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэхэмжлэхээр авч 29,100.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Эм эмнэлгийн хэрэгслийн үнэнд 2,205.4 мянган төгрөгийг илүү шилжүүлснийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй зөрчил албан шаардлага өгсөн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 150,867.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 213,201.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Түүхий эд материал	70,893.4	13,287.2	-57,606.2
Тусгай зориулалттай материал			0.0
Эм боох материал	70,893.4	13,287.2	-57,606.2
Хангамжийн материал	293,175.2	137,580.2	-155,595.0
Бичиг хэргийн материал	9,224.8	5,966.5	-3,258.3
Аж ахуйн материал	211,707.5	79,772.6	-131,934.9
Сэлбэг хэрэгсэл	8,525.8	8,068.5	-457.3
Барилгын засварын материал	34.0		-34.0
Хүнсний материал	6,548.8		-6,548.8
Бусад хангамжийн материал	23,199.3	11,367.6	-11,831.7
Мал амьтад	33,935.0	32,405.0	-1,530.0
Дүн	364,068.6	150,867.4	-213,201.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 150,867.4 мянган төгрөгийн байгууллагын төрлөөр задалбал 88,8 хувийг ЗДТГ, 8,68 хувийг эмийн эргэлтийн сан, 2,5 хувийг ИТХ-ын бараа материалын үлдэгдэл эзэлж байна. Нийт бараа материалын дансны үлдэгдлийг дансны төрлөөр задалбал 52,9 хувийг аж ахуйн материал, 21,5 хувийг мал амьтад, 8,8 хувийг эм боох материал, 7,5 хувийг бусад хангамжийн материал, 5,3 хувийг сэлбэг хэрэгсэл, 3,9 хувийг бичиг хэргийн материалын үлдэгдэл эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,867.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 213,201.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 203,547.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

Тус сумын ЭЭС нь Санхүүгийн тайланд тусгасан бараа материалын үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган шалгахад 13,107.2 мянган төгрөгийн бараа материалын тооллогын бүртгэл байхгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,480,068.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,739,504.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Биет хөрөнгө	5,162,364.2	1,476,852.0	-3,685,512.2
Барилга, байгууламж, орон сууц	4,374,120.9	918,366.7	-3,455,754.2
Авто-тээврийн хэрэгсэл	76,921.1	54,669.9	-22,251.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	160,667.4	63,978.1	-96,689.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	51,477.9	26,323.2	-25,154.7
Бусад үндсэн хөрөнгө	499,177.0	413,514.1	-85,662.9
Биет бус хөрөнгө	57,208.0	3,216.0	-53,992.0
Програм хангамж	882.0	882.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	56,326.0	2,334.0	-53,992.0
Дүн	5,219,572.2	1,480,068.0	-3,739,504.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,8 хувь буюу 1,477,383.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,18 хувь буюу 2,552.1 мянган төгрөгийг ИТХ, 0,01 хувь буюу 132.0 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,480,068.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,739,504.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,039,709.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд тайлант онд 128,364.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 257,450 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 368,814.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэн ба 1,334.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн данснаас хассан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 11,358.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,101.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Ө глөг	4,257.7	0.0	-4,257.7
Ажилчидтай холбогдсон ө глөг	994.7	0.0	-994.7
Бараа үйлчилгээний зардлын ө глөг	870.2	0.0	-870.2
Бусад өглөг	2,392.8	11,358.8	8,966.0
Байгууллагад төлөх өглөг	2,292.8	6,458.8	4,166.0
Хувь хүмүүст төлөх өглөг	100.0	4,900.0	4,800.0
Дүн	4,257.7	11,358.8	7,101.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдлийн 85,8 хувь буюу 9,749.0 мянган төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн сан, 5,4 хувь буюу 609.8 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого, 4,4 хувь буюу 500.0 мянган төгрөгийг Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан, 4,4 хувь буюу 500.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл эзэлж байна.

Өглөг дансны үлдэгдэл 11,358.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,101.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сан 8,799.0 мянган төгрөгөөр, Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан 500.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,902,190.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,802,918.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Засгийн газрын хувь оролцоо	6,705,108.9	2,902,190.0	-3,802,918.9
Засгийн газрын оруулсан капитал	1,266,753.6	481,759.6	-784,994.0
Хуримтлагдсан үр дүн	3,456,434.2	2,117,902.8	-1,338,531.4
Өмнөх үеийн үр дүн	2,776,571.6	5,840,684.5	3,064,112.9
Тайлант үеийн үр дүн	679,862.7	-3,722,781.7	-4,402,644.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,981,921.1	302,527.6	-1,679,393.4
Дүн	6,705,108.9	2,902,190.0	-3,802,918.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,902,190.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,802,918.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 3,802,918.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 66.1-д “Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 66.1.1-д “тухайн шатны **төсвийн төсөл**, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах” гэсэн заалтын дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын төсвийн төслийг нэгтгэж боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Баянцагаан сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 01 тоот тогтоолоор нийт дүнгээр 67,980.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгон баталсан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 262,298.3 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 511,932.8 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 32,364.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 240,214.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээр 531,693.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 173,000.0 мянган төгрөгийн нийт 1,751,502.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 266,267.7 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 511,932.8 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 240,214.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 55,582.1 мянган төгрөгийн нийт 1,073,997.2 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 701,668.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 173,000.0 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 55,738.7 мянган төгрөг бүрдүүлж 117,261.3 мянган төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 262,298.3 мянган төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр нийт 400,221.4 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 137,923.4 мянган төгрөгөөр буюу 152,6 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь нэр зааж ангилагдаагүй орлого 137,562.7 мянган төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс илүү нэмж төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

Татварын болон татварын бус орлогыг тасарсан нэр төрлөөр нь задалбал хөрөнгийн орлого 4,269.9 мянган төгрөг, суутган2 орлого 586.5 мянган төгрөг, галт зэвсгийн татвар 300.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 15,578.6 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 1,474.5 мянган төгрөг, хог хаягдлын хураамж 203.0 мянган төгрөг, газрын төлбөр 5,864.6 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын 2022 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 1,751,502.7 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 1,081,885.6 мянган төгрөг буюу 669,617.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 61,77 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 18,504.9 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 10,786.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 77.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,160.5 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 24.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 3,902.4 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал 2,122.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 93.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 559,316.6 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 73,634.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн /70106 /	431,694.8	417,943.6	13,751.2	96.8
2	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн /70105/	72,813.9	71,609.4	1,204.5	98.3
3	Ерөнхий боловсрол хөтөлбөрийн /71802/	174,330.3	170,817.6	3,512.7	98.0
4	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн /71801/	34,201.5	25,653.1	8,548.4	75.0
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн /71602/	30,397.1	22,765.5	7,631.6	74.9
6	Соёл урлаг хөтөлбөрийн /71702/	23,157.5	21,140.0	2,017.5	91.3
7	Орон нутгийн хөгжлийн сан	811,907.6	252,591.0	559,316.6	31.1
8	Хоршоо хөгжүүлэх сан	173,000.0	99,365.4	73,634.6	57.4
Нийт дүн		1,751,502.7	1,081,885.6	669,617.1	61.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 188,289.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 43,432.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 23,832.2 мянган төгрөг, оны эхний үлдэгдэл болох эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 2,497.9 мянган төгрөгийг хүн эмнэлгийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 21,024.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Хурлын төлөөлөгч, Хурлын зөвлөл, Хороодын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаануудыг зохион байгуулж, баталсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг дүгнэж үр дүнг тооцож ажиллана. ИТХ-ын уралдааныг Ээлжит хуралдаан- 4. ээлжит бус-3 ,багын ИНХ-ын 15 удаа зохион байгуулна. ГХУСАЗЗөвлөлийн төлөвлөгөөг ханган биелүүлнэ.	ИТХ-ын Хурлын хуралдаан 7 удаа хуралдаж 39 асуудал хэлэлцэн шийдвэрлэж хэлэлцэх асуудлын төлөвлөгөө 90 хувьтай хэрэгжсэн. Сумын ИТХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 20 хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөж, тайланг 14-р хуралдаанд хэлэлцүүлж 83.5 хувийн биелэлттэй "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн. ГХУСАЗЗөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд 25 арга хэмжээ төлөвлөж хэрэгжилт 87.9 хувьтай хангагдсан. 2022 онд багийн ИНХ-ын хуралдааныг 9 удаа баг бүрт 1-2 удаа/ зохион байгуулж 576 иргэн оролцож 33 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.	72,813.9	71,609.4
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 8 зорилт, хэрэгжүүлэх 193 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 84.6 %	431,694.8	417,943.6
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100% Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн 11 иргэнд 99.4 сая төгрөгийг олгосон байна.	173,000.0	99,365.4
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Дулаан , цахилгаанаар бүрэн хангах	Дулаан , цахилгаанаар бүрэн хангасан	174,330.3	170,817.6
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Дулаан , цахилгаанаар бүрэн хангах	Дулаан , цахилгаанаар бүрэн хангасан	34,201.5	25,653.1
6	71702- Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Дулаан , цахилгаанаар бүрэн хангах	Дулаан , цахилгаанаар бүрэн хангасан	23,157.5	21,140.0
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Дулаан , цахилгаанаар бүрэн хангах	Дулаан , цахилгаанаар бүрэн хангасан	30,397.1	22,765.5
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 23 төслийг гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл хэрэгжсэн , мөнгийг нь дутуу шилжүүлсэн 1 ажил байна. Хэрэгжилт 43,4 %	811,907.6	252,591.0
Нийт дүн					1,751,502.7	1,081,885.6

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нь Хөрөнгө оруулалтын ажлын тендер зарлагдаад оролцогч ирээгүйгээс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажил бүрэн хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 1,751,502.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 26,272.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,704.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын шилэн дансны мэдээллийг шалгахад Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл болон 2022 оны 4-р улиралд шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын ОНХС-гийн хувьд Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасан тендер шалгаруулалттай холбоотой 11 ажил мэдээлэхээс огт мэдээлээгүй, 6.4.8-д заасан 13 ажлын гэрээ шийдвэр мэдээлэхээс 1 ажлаас бусад ажлын мэдээллийг оруулаагүй нийт 669,626.3 мянган төгрөгийн ажил оруулаагүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын ХХС-ийн хувьд төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 шийдвэр гарсныг мэдээлээгүй, орон нутгийн тусгай сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл нийт 237,675.9 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын ЭЭС-ийн хувьд 5.0 сая төгрөгөөс дээш 17,385.9 мянган төгрөгийн 3 зарлага мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар газар худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 03/416 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	5	148,580.1	5	104,006.1	70.0
Зөвлөмж	6	99,541.1	6	69,678.8	70.0
Нийт дүн	11	248,121.2	11	173,684.8	70.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын дараагийн аудитаар орлого бүрдүүлэлт, баяр наадмын хандивын орлого, нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт зэрэг асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 409,158.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 409,158.5 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Улсын төсөв рүү шилжсэн байгууллагуудын хаалтын балансыг давтан шалгахад 409,158.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 28,308.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргах байх 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Татварын болон татварын бус орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй.

Илрүүлэлт:

Орон нутагт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 8 нэр төрөлд 28,280.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 24 дүгээр зүйлийн 24.3-д “Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “толилуулга”, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, татварын орлогыг бааз суурийг нэмэгдүүлэх, орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар үр дүнд хүрсэн ажил зохион байгуулах

2.Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын хэлтсийн гаргасан мэдээ 400,193.0 мянган төгрөг, санхүүгийн нэгтгэсэн тайланд 400,221.4 мянган төгрөг буюу 28.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Татварын болон татварын бус орлогын мэдээг орлогын дансны хуулганаас зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, мэдээний үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын шилэн дансны мэдээллийг шалгахад Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл болон 2022 оны 4 дүгээр улиралд шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй, ОНХС-гийн хувьд Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасан тендер шалгаруулалттай холбоотой 11 ажил мэдээлэхээс огт мэдээлээгүй, 6.4.8-д заасан 13 ажлын гэрээ шийдвэр мэдээлэхээс 1 ажлаас бусад ажлын мэдээллийг оруулаагүй нийт 669,626.3 мянган төгрөгийн ажил оруулаагүй, ХХС-ийн хувьд төсөв хөрөнгө зарцуулахтай

холбоотой 1 шийдвэр гарсныг мэдээлээгүй, орон нутгийн тусгай сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл нийт 237,675.9 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, ЭЭС-ийн хувьд 5.0 сая төгрөгөөс дээш 17,385.9 мянган төгрөгийн 3 зарлага мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах тушаал, шийдвэрийн мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх, мэдээллийг бүрэн, ойлгомжтой мэдээлсэн эсэхэд тавих дотоод хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга	1	409158.5			1	409,158.5	1	409,158.5				
Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар	4	178534.9			4	178,534.9	4	178,534.9				
Дүн	5	587,693.4	-	-	5	587,693.4	5	587,693.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга	3	28,308.4					3	28,308.4
Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар	3	23,182.2	1	311.0	1	10,500.0	1	12,371.2
Төв аймгийн Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	7,500.0			1	7,500.0		
Төв аймгийн Баянцагаан сумын Эргэлтийн эмийн сан	3	26,754.7			3	26754.7		
Дүн	10	58,990.6	1	311.0	5	44,754.7	4	40,679.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга	1	46,737.5					1	46,737.5
Төв аймгийн Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	304,759.6					1	304,759.6
Төв аймгийн Баянцагаан сумын Эргэлтийн эмийн сан	1	17,385.9					1	17,385.9
Төв аймгийн Баянцагаан сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	237,675.9					1	237,675.9
Дүн	4	606,558.9					4	606,558.9

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1		1			
2	ОНТС	4		4					
3	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	7	2	5	-	2			